



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/09/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70357955 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Аудитор: Г.Даваасүрэн

Утас: 70350757 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.13 № 03
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА Г.ГАНБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Онцгой байдлын газар нь 2022 оны санхүүгийн тайлангийн хугацаанд улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 2,895,416.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 520,410.6 мянган төгрөг, Онцгой байдлын ерөнхий газраас 35,521.8 мянган төгрөг, бусад төсөвт байгууллагаас 635.0 мянган төгрөг нийт 3,451,983.7 мянган төгрөгийг зардлын зүйл ангиар зарцуулсан байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Онцгой байдлын газар "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 5 га газарт 7500 ширхэг үхрийн нүд модны үрсэлгээ суулган гүний худаг, хашаа барих зэрэг мод тарихтай холбоотой ажлуудыг хийсэн байна. Мөн Онцгой байдлын ерөнхий газраас шуурхай албаны зориулалт бүхий 325,729.9 мянган төгрөгийн үнэлгээтэй 2 авто машиныг хүлээн авсан байна. Санхүүгийн тайлангийн тухайд толилуулсан, тодруулсан мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулга хэсгээс харах боломжтой.

Бусад асуудлын хэсэг

Орхон аймгийн Онцгой байдлын газрын дарга нь аймгийн Онцгой байдлын комиссын нарийн бичгийн үүргийг хийж гүйцэтгэдэг бөгөөд тус комиссын санхүүгийн зарцуулалт нь Онцгой байдлын газрын нэмэлт дансаар хийгддэг байна. Нэмэлт дансны зарцуулалттай холбоотой зардлууд нь байгууллагын урсгал зардлыг дүнд нөлөөлж байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,294,149,209.97	1,660,026,773.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,447,033.00	4,352,529.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,447,033.00	4,352,529.00
3121	Төгрөг	7,447,033.00	4,352,529.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	7,447,033.00	4,352,529.00
33	АВЛАГА	32,772,397.00	10,495,067.00
335	Бусад авлага	32,772,397.00	10,495,067.00
3351	Байгууллагаас авах авлага	32,772,397.00	10,495,067.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,253,929,779.97	1,645,179,177.77
351	Түүхий эд материал	1,145,065,483.52	1,252,006,883.52
35110	Тусгай зориулалттай материал	1,143,310,675.32	1,250,252,075.32
35130	Эм боох материал	1,754,808.20	1,754,808.20
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	262,228,494.00
354	Хангамжийн материал	108,864,296.45	87,068,800.25
35410	Бичиг хэргийн материал	5,963,175.25	7,898,825.25
35420	Аж ахуйн материал	31,452,575.00	31,452,575.00
35430	Сэлбэг хэрэгсэл	21,144,200.00	19,699,200.00
35470	Бусад хангамжийн материал	19,038,800.00	28,018,200.00
35500	Биологийн хөрөнгө	00.00	43,875,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,644,292,746.18	9,584,246,696.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,644,292,746.18	9,584,246,696.22
392	Биет хөрөнгө	8,258,607,546.18	8,118,561,496.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,242,773,318.83	2,488,306,472.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-177,826,498.87	-246,781,913.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,468,274,576.33	7,826,004,466.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,330,355,102.32	-1,984,541,419.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	486,940,538.72	491,888,811.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	-458,596,408.32	-474,603,953.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,741,680.00	32,661,480.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,772,946.38	-31,556,169.84
39214	Бусад үндсэн хөрөнгө	314,696,306.80	314,696,306.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-289,267,918.61	-297,512,585.37
393	Биет бус хөрөнгө	1,385,685,200.00	1,465,685,200.00
39301	Програм хангамж	900,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-900,000.00	-900,000.00

39303	Бусад биет бус хөрөнгө	1,385,685,200.00	1,465,685,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,938,441,956.15	11,244,273,469.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,938,441,956.15	11,244,273,469.99
51	Засгийн газрын хувь оролцоо	10,938,441,956.15	11,244,273,469.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,246,725,655.74	2,246,725,655.74
51101	Өмч: - төрийн	2,246,725,655.74	2,246,725,655.74
512	Хуримтлагдсан үр дүн	6,780,381,473.58	7,086,212,987.42
51210	Өмнөх үеийн үр дүн	6,780,381,473.58	6,780,381,473.58
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	305,831,513.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,911,334,826.83	1,911,334,826.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,938,441,956.15	11,244,273,469.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,412,745,459.99	4,522,828,981.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	342,684,293.00	1,089,078,721.00
120	Нийтлэг татварын бус орлого	332,304,293.00	1,089,078,721.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	327,454,293.00	299,012,764.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	327,454,293.00	299,012,764.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,070,061,166.99	3,433,750,260.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,193,978,500.00	2,895,416,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,193,978,500.00	2,895,416,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,046,808,393.99	538,333,960.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,422,650,441.00	502,212,150.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,230,000.00	35,521,810.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	537,427,952.99	600,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,910,103,212.82	4,216,997,467.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,910,103,212.82	4,216,997,467.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,766,764,072.89	4,200,756,448.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,551,779,869.00	2,521,617,549.00
210101	Үндсэн цалин	1,465,090,669.00	1,471,966,749.00
210102	Нэмэгдэл	1,033,280,800.00	997,309,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,408,400.00	52,341,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,393,566.00	61,815,787.00

210201	Тэтгэврийн даатгал	8,794,700.00	9,113,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,034,700.00	1,072,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	827,700.00	857,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	206,900.00	214,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	52,529,566.00	50,558,287.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,227,542.06	65,827,398.97
210301	Гэрэл, цахилгаан	12,769,946.50	9,369,783.97
210302	Түлш, халаалт	51,589,135.56	48,474,140.00
210303	Цэвэр, бохир ус	3,868,460.00	7,983,475.00
2104	Хангамж, бараа материалын зардал	154,643,881.30	161,384,973.00
210401	Бичиг хэрэг	3,676,763.30	1,819,750.00
210402	Тээвэр, шатахуун	148,989,470.00	157,733,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,394,648.00	1,171,553.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	583,000.00	660,000.00
2105	Нормативт зардал	562,178,546.15	137,092,392.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,037,059.00	613,500.00
210502	Хоол, хүнс	81,644,030.80	136,478,892.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	131,656,174.00	54,874,575.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,460,882.00	3,945,961.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	88,277,892.00	18,045,139.00
210604	Урсгал засвар	37,917,400.00	32,883,475.00
2107	Томилолт, зочны зардал	22,882,500.00	54,678,037.00
210701	Гадаад албан томилолт	00.00	46,695,033.00
210702	Дотоод албан томилолт	22,882,500.00	7,983,004.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,395,556.00	11,988,072.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,710,000.00	1,710,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	906,956.00	1,857,672.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,038,400.00	3,179,000.00
210807	Газрын төлбөр	3,725,900.00	5,241,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,197,606,438.38	1,131,477,663.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,612,257,022.00	372,244,297.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	10,056,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	585,349,416.38	749,177,166.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,339,139.93	16,241,019.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,228,330.00	12,399,703.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,228,330.00	12,399,703.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,005,444.94	3,841,316.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,005,444.94	3,841,316.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,502,642,247.17	305,831,513.84
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,502,642,247.17	305,831,513.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,245,636,893.99	3,451,983,768.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,240,786,893.99	3,451,983,768.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,193,978,500.00	2,895,416,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,193,978,500.00	2,895,416,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,046,808,393.99	556,567,468.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,422,650,441.00	520,410,658.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,230,000.00	35,521,810.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	537,427,952.99	635,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,024,346,893.99	3,426,378,272.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,024,346,893.99	3,426,378,272.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,881,007,754.06	3,391,903,744.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,551,779,869.00	2,521,617,549.00
210101	Үндсэн цалин	1,465,090,669.00	1,471,966,749.00
210102	Нэмэгдэл	1,033,280,800.00	997,309,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,408,400.00	52,341,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,393,566.00	61,815,787.00
210201	Тэтгэврийн даатгал	8,794,700.00	9,113,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,034,700.00	1,072,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	827,700.00	857,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	206,900.00	214,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	52,529,566.00	50,558,287.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,227,522.06	65,827,398.97
210301	Гэрэл, цахилгаан	12,769,926.50	9,369,783.97
210302	Түлш, халаалт	51,589,135.56	48,474,140.00
210303	Цэвэр, бохир ус	3,868,460.00	7,983,475.00
2104	Хангамж, бараа материалын зардал	134,218,050.00	84,656,113.00
210401	Бичиг хэрэг	1,521,680.00	1,188,100.00
210402	Тээвэр, шатахуун	130,707,070.00	81,636,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,406,300.00	1,171,553.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	583,000.00	660,000.00
2105	Нормативт зардал	371,223,750.00	108,144,446.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	631,750.00	613,500.00

210502	Хоол, хүнс	110,592,000.00	107,530,946.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,742,900.00	87,417,875.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,914,300.00	3,700,000.00
210604	Урсгал засвар	37,828,600.00	83,717,875.00
2107	Томилолт, зочны зардал	22,882,500.00	54,678,037.00
210701	Гадаад албан томилолт	00.00	46,695,033.00
210702	Дотоод албан томилолт	22,882,500.00	7,983,004.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,315,256.00	11,988,072.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,710,000.00	1,710,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	906,956.00	1,857,672.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,179,400.00	3,179,000.00
210807	Газрын төлбөр	3,725,900.00	5,241,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,609,224,341.00	395,758,467.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,598,309,779.00	385,444,967.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,914,562.00	10,313,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,339,139.93	34,474,527.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,228,330.00	12,399,703.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,228,330.00	12,399,703.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,005,444.94	3,841,316.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,005,444.94	3,841,316.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	101,105,364.99	18,233,508.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,105,364.99	18,233,508.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	221,290,000.00	25,605,496.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	228,340,000.00	28,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	228,340,000.00	28,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	228,340,000.00	28,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	228,340,000.00	28,700,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-228,340,000.00	-28,700,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-7,050,000.00	-3,094,504.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,497,033.00	7,447,033.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,447,033.00	4,352,529.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,691,998.67	4,277,382,054.57	8,435,799,708.98
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	357,171.84	357,171.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,691,998.67	4,277,739,226.41	8,436,156,880.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,502,642,247.17	2,502,642,247.17
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,334,826.83	6,780,381,473.58	10,938,441,956.15
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,334,826.83	6,780,381,473.58	10,938,441,956.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,334,826.83	6,780,381,473.58	10,938,441,956.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	305,831,513.84	305,831,513.84
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,334,826.83	7,086,212,987.42	11,244,273,469.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,895,416,300.00	2,897,819,487.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,895,416,300.00	2,897,819,487.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,888,026,500.00	2,887,642,784.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,522,285,900.00	2,521,617,549.00
210101	Үндсэн цалин	1,482,745,300.00	1,471,966,749.00
210102	Нэмэгдэл	997,311,600.00	997,309,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,229,000.00	52,341,000.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,148,500.00	61,815,787.00
210201	Тэтгэврийн даатгал	9,113,200.00	9,113,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,072,200.00	1,072,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	857,600.00	857,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	214,500.00	214,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	52,891,000.00	50,558,287.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,835,500.00	65,827,398.97
210301	Гэрэл, цахилгаан	18,767,700.00	9,369,783.97
210302	Түлш, халаалт	38,093,800.00	48,474,140.00
210303	Цэвэр, бохир ус	8,974,000.00	7,983,475.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,021,000.00	5,019,653.00
210401	Бичиг хэрэг	1,097,700.00	1,188,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,316,800.00	1,171,553.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	606,500.00	660,000.00
2105	Нормативт зардал	106,044,500.00	106,044,446.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	613,500.00	613,500.00
210502	Хоол, хүнс	105,431,000.00	105,430,946.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	101,418,500.00	101,417,875.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,700,500.00	3,700,000.00
210604	Урсгал засвар	97,718,000.00	97,717,875.00
2107	Томилолт, зочны зардал	964,400.00	603,004.00
210702	Дотоод албан томилолт	964,400.00	603,004.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,989,700.00	11,988,072.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,710,700.00	1,710,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,858,200.00	1,857,672.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,179,400.00	3,179,000.00
210807	Газрын төлбөр	5,241,400.00	5,241,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10318500.00	13309000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,995,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,318,500.00	10,313,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7389800.00	10176703.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,389,800.00	10,176,703.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,389,800.00	10,176,703.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,895,416,300.00	2,898,566,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,895,416,300.00	2,895,416,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,895,416,300.00	2,895,416,300.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	7,447,033.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	4,352,529.00

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		189.00	189.00
620001	Удирдах ажилтан		1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан		176.00	176.00
620003	Үйлчлэх ажилтан		12.00	12.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		535,183,960.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		535,183,960.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		532,960,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал		79,636,460.00
210402	Тээвэр, шатахуун		79,636,460.00
2105	Нормативт зардал		2,100,000.00
210502	Хоол, хүнс		2,100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		14,700,000.00
210604	Урсгал засвар		14,700,000.00
2107	Томилолт, зочны зардал		54,075,033.00
210701	Гадаад албан томилолт		46,695,033.00
210702	Дотоод албан томилолт		7,380,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		382,449,467.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		382,449,467.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,223,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,223,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,223,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		553,417,468.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		553,417,468.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		520,410,658.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		32,371,810.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		635,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 23,315.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 2,275.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 9,900.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 11,140.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аймгийн Засаг даргын 2022 оны А/578 дугаар захирамжаар Австрали улсын Брисбейн хотод 2022 оны 09 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд болох "Гамшгийн эрсдэлийг бууруулах Ази, Номхон далайн бүсийн сайд нарын бага хурал"-д Орхон аймгаас оролцсон төлөөлөгч нарын онгоцны тийз, зочид буудал, зам хоногийн тооцоог бодит зардал болон Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад томилолтын зардлын хэмжээ"-нээс 2,275.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

5.2 Албан шаардлага

1. Аймгийн Онцгой байдлын газрын дарга нь зэх зээлийн үнээс нийт 1,900,0 мянган төгрөгийн өндөр үнэлгээтэй гэрээгээр цутгамал бетонон хашаа хийлгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" хэсэгтэй нийцэхгүй байна.

2. Аймгийн Засаг даргын 2022 оны А/578 дугаар захирамжаар Австрали улсад томилолтоор явсан 3 албан тушаалтан БНСУ-ын агаарын тээврийн KOREAN AIR компаниар үйлчлүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9.2-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ." хэсгийг зөрчиж байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Онцгой байдлын газрын дарга нь ээлжийн амралтаа биеэр эдлээгүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1-д "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." хэсгийг зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийг ханган ээлжийн амралтын тооцоог хийх

2. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар Төрийн тусгай байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарахгүй мод тарих ажилд албан хаагчдыг дайчилж, Урсгал засварын зардлаас мод тарих ажилд шаардагдах модны суулгац, ажлын хөлс, гүний худаг шинээр байгуулах, хашааны материал зэрэг зардлуудыг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22.1-т "төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.", Төрийн албаны тухай хуулийн 49.3-т. "Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд дайчлах, чиг үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно." хэсгийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнах.

3. Өмч хөрөнгө тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын нягтлан бодогч өндөр насны тэтгэвэрт гарахад хөрөнгийн тооллого хийгээгүй байна. Энэ нь НББТ хуулийн 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" хэсгийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед даргын тушаалаар хөрөнгийн тооллого хийж хэвших

4. Өр авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 9,722.6 мянган төгрөгийн өртөгтэй газар хөдлөлтийн чичирхийллийг хэмжих зориулалттай төхөөрөмжийг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүлээн авахаар гэрээ хийж, төлбөрийг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр шилжүүлэн авлагын дүнг нэмэгдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" хэсгийг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Онцгой байдлын газар	7	23,315.4	1	2,275.2	2	9,900.0	4	11,140.2	7	23,315.4		
Дүн	7	23,315.4	1	2,275.2	2	9,900.0	4	11,140.2	7	23,315.4		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	+			+			
2									
	НИЙТ		+			+			